Дундговь аймгийн Сайнцагаан сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн явцын хэрэгжилтийн товчоо

/ 2018 оны 11 дүгээр сарын байдлаар /

| № | Агуулга | Арга хэмжээний тоо | Бүрэн хэрэгжсэн | үүнээс | | | | Нийт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 70 | 40 | 0 | ҮБ-гүй | |
| 1 | ЗАСАГЛАЛЫН ХҮРЭЭНД | 23 | 20 | 2 | 1 | | | 94,8 |
| 2 | ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭНД | 8 | 6 | 1 | 1 | | | 88,75 |
| 3 | НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД | 52 | 41 | 7 | 1 | 2 | 1 | 89 |
| 4 | ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮРЭЭНД | 34 | 29 | 3 | 1 | | 1 | 92,6 |
| 5 | БАЙГАЛЬ ОРЧИН,ГАЗАР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, УУЛ УУРХАЙН ХҮРЭЭНД | 17 | 7 | 6 | 4 | | | 75,2 |
| 6 | БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХҮРЭЭНД | 21 | 6 | 4 | | | 11 | 41,9 |
| **Нийт** | | **155** | **109** | **23** | **8** | **2** | **13** | **82,7** |

Эрчимжүүлэх шаардлагатай болон тасарч болзошгүй заалтуудыг харуулбал

| № | Зорилт | 40 хувь | 0 хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Төрийн захиргаа | 1 | | |
| 2 | Цэрэг ,гамшгаас хамгаалах | | | |
| 3 | Хууль эрх зүй | | | |
| 4 | Боловсрол | 1 | | |
| 5 | Эрүүл мэнд | | | |
| 6 | Гэр бүл хүүхэд хамгаалал | | | |
| 7 | Соёл ,спорт | | | |
| 8 | МЭҮТасаг | 1 | | |
| 9 | Сум хөгжүүлэх сан | | | |
| 10 | ОНХСан | | | |
| 11 | Санхүүгийн алба | 1 | | |
| 12 | Худалдаа үйлчилгээ | | | |
| 13 | Газар ,Байгаль орчин | 4 | | |
| 14 | Дэд бүтэц бүтээн байгуулалт | | | |
| **Нийт** | | | | |

**ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

**2018.12.11.**

| ЗДҮАХ-т тусгагдсан, зорилт | Арга хэмжээний № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан Хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төг) | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, хэрэгжилт | хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **НЭГ.ЗАСАГЛАЛЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| **1.1.Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах** | 1 | 1.1.1. Сумын боловсон хүчний нөөцийн судалгааг гарган, төрийн албан хаагчдыг тогтвортой ажиллуулна. | 2016-2020 | | Байгууллага бүр дутагдалтай боловсон хүчнийг хангах арга хэмжээ авна. | Сумын засаг даргын зөвлөлийн хурлаар Хүний нөөцийн бодлого,төлөвлөгөөг хэлэлцэн, засаг даргын 2017 оны А/113 тоот захирамжаар батлууллаа. Сумын харьяа төсөвт 14 байгууллагад **579** албан хаагч ажиллаж байна. Сумын хэмжээнд одоогийн байдлаар мэргэжилтэй ажил эрхлээгүй 35 хүртэлх насны /дээд, тусгай дунд / 314 иргэний судалгаа гарлаа. Үүнээс: Төвийн багт 189, хөдөөгийн багт 125. Цаашид эрүүл мэндийн төвд их эмч, цэцэрлэгт дуу хөгжмийн багш дутагдах хандлагатай. | 70 |
| | 2 | 1.1.2. Төрийн албан хаагчдыг чадваржуулах ажлыг зохион байгуулж, төрийн үйлчилгээг иргэдэд хүнд сурталгүй, ил тод хүртээмжтэй хүргэнэ. | 2016-2020 | Сонин 2000.0 | байгууллагу удад томилгооны, хууль эрх зүйн зөрчилгүй ажиллана. | Одоогийн байдлаар нийт 263 сургалтанд / орон нутгийн бүсийн /сумын ЗДТГазрын 22, боловсролын байгууллагын багш, ажилчид/ давхардсан тоогоор 5074 албан хаагч хамрагдлаа.<br>Үйл ажиллагааны мэдээллээ “Сүүн-цагаан Сайнцагаан” сониноор дамжуулан иргэдэд хүргэж, 12000 ш сонин хэвлүүлж, 264 мэдээллийг иргэдэд хүргэлээ. Төрийн албан хаагчдад 21 хуулиар сургалт явууллаа.Багууд нийт 6500 гаруй иргэнд хууль,эрх зүйн сургалт явууллаа. | 100 |
| | 3 | 1.1.3.Төрийн албан хаагчдыг гадаад дотоодод туршлага судлуулах,мэргэшүүлэх,сургалтанд хамруулах боломжийг нэмэгдүүлнэ. | 2016-2020 | | Төрийн албан хаагчдын 5 дээш хувийг хамруулна. | Нарлаг багийн засаг дарга, Хот тохижуулах ОНӨААТҮГазрын дарга нар БНХАУ-ын Эрээн хотод ногоон байгууламжийн талаар 7 хоног туршлага судлаж, сургалтанд, сумын засаг дарга Солонгос улсын Гуяань,Япон улсад туршлага судаллаа.<br>Тус сумын ЗДТГазрын албан хаагчид Өмнөговь аймгийн Даланзадгад сумын ЗДТГазартай туршлага судлах арга хэмжээг зохион байгуулж, 23 албан хаагч оролцлоо. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 4 | 1.1.4.Малчдыг мэдээллээр хангах,тэднийг төрийн үйл ажиллагаанд оролцох боломжийг нэмэгдүүлж, явуулын үйлчилгээг улирал бүр хүргэнэ. | 2016-2020 | | | Хөдөөгийн багууд багийн хурал цуглааныг улирал бүр хийж, / Наран баг 4 удаа– 18, Тэвш баг 3 удаа 16, Далай баг 5 удаа 15 , Үйзэн баг 3 удаа 16 / 65 асуудлыг шийдвэрлэж, 1048 иргэнийг хамрууллаа.Сумын засаг даргын А/82 тоот захирамжаар хөдөөгийн багуудад ажиллалаа. Уг ажлын хүрээнд удирдлагууд, багийн засаг дарга нар,хүн эмнэлэг ,мал эмнэлэг , орон нутгийн цаг үеийн мэдээлэл хийэ, 18 удаа 1212 өрхөд /давхардсан тоогоор / төрийн үйлчилгээг хүргэлээ. Сумын сонинг сар бүр багийн засаг дарга нарт хүргэлээ. | 100 |
| | 5 | 1.1.5. Нутгийн захиргааны байгууллагаас бодлого боловсруулах, шийдвэр гаргахад иргэд,ИНБайгууллагын оролцоог нэмэгдүүлж, төрийн зарим чиг үүргийг ТББ-уудаар гүйцэтгүүлнэ. | 2016-2020 | | ТББайгууллагатай хамтарч ажиллах гэрээ байгуулсан байх. | “Дэлхийн зөн” ОНХХөтөлбөр, Оюуны гэгээ ТББайгууллагатай ажлын гэрээ байгуулан ажиллалаа. “Хүүхдэд ээлтэй” дотуур байр хөтөлбөрийн хүрээнд дотуур байрны 186 сурагчдад харилцаа хандлага , зөв дадал хэвшилд сургах ,Хүүхэд хамгаалал , Гэр бүлийн хүчирхийллийн тухай-157 Жирэмсэн эхчүүдийн сургалтанд гэр бүлийн гишүүний хамтаар 40 иргэн , Баг, сургуулийн нийгмийн ажилтнуудад Кейс менежмент -10, Төрийн үйлчилгээний албан хаагчдын сургалт-54 , Жаргалтай гэр бүл аянд 40 өрхийн 80 иргэн , Эмэгтэйчүүд эрүүл бол үндэстэн эрүүл зэрэг сургалтанд 40 иргэнийг тус тус хамруулан нийт 700 гаруй албан хаагч иргэн , сурагч оролцлоо.“Жаргалтай гэр бүл” аяныг 2 сарын хугацаатай явуулж, зорилтот бүлгийн 40 өрх хамрагдаж, төрөл арга хэмжээнд оролцож, гэр бүлийн харилцаанд эрс өөрчлөлтийг хийхэд тус дэм боллоо. | 100 |
| | 5 | 1.1.6.Төрийн болон ОНӨХБараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд орон нутгийн иргэд, ААНэгжийг оролцуулах, ”Шилэн тендер”-ийн бодлого хэрэгжүүлнэ. | 2016-2020 | 170.0 сая | Шилэн тендер, шилэн дансны хэрэгжилтийг хангаж ажиллах | Сумын ЗДТГ-аас зарлагдсан 21 тендерийг 100 хувь цахимаар зохион байгуулж, мэдээллийг хууль журмын дагуу www.tender.gov.mnсайтанд байршуулан нээлттэй тендер шалгаруулалтын зарыг өдөр тутмын сонинд хэвлүүллээ. Аймгийн ОНӨГазраас зохион байгуулсан цахим тендерт оролцох талаар ойлголт, мэдээлэл олгох сургалтанд 9 аж ахуй нэгжийг хамрууллаа. Ажил үйлчилгээ худалдан авах ажлыг зохион байгуулах үнэлгээний хороонд ажиллах А3 сертфитикатын сургалтанд 30 иргэн суралцанаас 28 иргэн амжилттай суралцан төгссөн өнгөрсөн оноос 21 хүнээр өссөн байна.Энэ онд үнэлгээний хороо 18 байгуулагдсан, тендерийн талаарх мэдээллийг Дундговь вэб сайт, Сүүн цагаан- Сайнцагаан сонин , сумын вэб сайтаар олон нийтэд хүргэлээ. Улсын төсвөөс 601,264,700 төгрөг, ОНХСангаас 129442,7 мянган төгрөг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зарцуулаад байна.Тендерт 60 гаруй ААНэгж, байгууллага оролцлоо. | |
| | 6 | 1.1.7. Гадаад харилцааг бүх чиглэлээр бий болгож, хамтран ажиллана. | 2016-2020 | | Хамтын ажиллагаа нэмэгдэнэ. | Одоогийн байдлаар Гуянийн төгөлийн үйл ажиллагаанд хамтран ажиллаж байна. | 40 |
| | 7 | 1.1.8.Төрийн албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлж, хариуцлагыг нэмэгдүүлж, хариуцсан ажлын мэдлэг,чадварыг сайжруулна. | 2016-2020 | | Төрийн албан хаагчдад үйлчилгээг шуурхай хүргэж, иргэдийн гомдолгүй ажиллана. | Засаг даргын захирамжаар ажлын байрны тодорхойлолт боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ,нийт 39 албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлууллаа.<br>Албан хаагчидтай хөдөлмөрийн болон ёс зүйн гэрээ шинээр байгуулах ажлыг зохион байгууллаа. Байгууллагууд албан хаагчдад Засгийн газрын 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, нийт 20 албан хаагчдад сахилгын хариуцлага тооцлоо. Иргэнээс 2 албан хаагчид үйл ажиллагаатай холбоотой гомдол ирснийг барагдууллаа. | 100 |
| **1.2.Хууль ёсыг бэхжүүлж,иргэдийн оролцоог нэмэгдүүлэх** | 8 | 1.2.1.Захиргааны ерөнхий хуулийг албан хаагч бүр хариуцсан ажилдаа хэрэгжүүлж, шийдвэр гаргахад иргэдийг оролцуулан, тэдний эрхийг хамгаална. | 2016-2020 | | Хуулийн хэрэгжилт хангагдана. | Захиргааны ерөнхий хууль, зөрчлийн тухай хуулиар харьяа байгууллагын удирдлагууд болон албан хаагчиддаа сургалтыг зохион байгууллаа. Иргэдийн санал санаачлагад үндэслэн сумын 3 дэд хөтөлбөрийг хэрэгжүүллээ.<br>Сумын засаг дарга бүрэн эрхийн хугацаанд А захирамж 477, Б захирамж 47 –ыг гаргасан байна. Улирал бүр захирамжийг хянуулж зөвлөмжийг хэрэгжүүллээ. | 100 |
| | 9 | 1.2.2.”Иргэний эрх зүйн боловсрол” аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэдийн хууль эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ. | 2016-2017 | | -Эрх зүйн хөтөч орон тооны бус багийн үйл ажиллагаа тогтмолжсон байна. | Сумын эрх зүйн хөтөч багийн хүрээнд багийн засаг дарга нар ГХУСэргийлэх зөвлөлтэй хамтран Гэмт хэрэг зөрчилгүй аюулгүй амар тайван орчин аяны хүрээнд болзолт уралдаан , тэмцээнүүдийг иргэд, ТАХаагчдын дунд хамтран зохион байгуулж, 400 гаруй иргэнийг хамруулаа. Далай багийн малчдын дунд багийн өдөрлөг зохион байгуулж 150 гаруй иргэн оролцож , Замын хөдөлгөөн , Хулгайн гэмт хэрэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудыг сурталчиллаа. “Хамтдаа шийдье” арга хэмжээний хүрээнд 6 уулзалт зохион байгуулж , 4 хуулиар гарын авлага боловсруулж 520 , хөдөөгийн 4 багийн нэгдсэн хурлаар 101 малчинд Бодь даатгал, малын индексжүүлсэн даатгалын,төвийн багуудын өдөрлөгөөр 272 иргэнд мэдээлэл өглөө. Дээрх арга хэмжээнүүдэд нийт 1443 иргэн хамрагдлаа.Төрийн албан хаагчийн заавал судлах хуулийн дагуу төсөвт мэргэжлийн байгууллагуудтай хамтран 13 төрлийн сургалтанд 417 албан хаагч хамрагдаж, Авилгын эсрэг олон | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | улсын өдрийг тохилдуулан төсөвт байгууллагуудын нийт 5 багийн 25 удирдах албан тушаалтны дунд “Элсэн цаг” хуулийн тэмцээнийг ХЭХэлтэс,Элгэмсэг дотно Дундговь ТББайгууллагатай хамтран зохион байгууллаа. Төвийн багуудын өдөрлөгийг хуваарийн дагуу зохион байгуулж , ИТХ-ын дарга, ЗДарга, мэргэжилтнүүд иргэдэд цаг үеийн болон цаашид орон нутагт хэрэгжүүлэх ажлын талаар мэдээлэл хийлээ<br>Багийн ИНХурлаар иргэдэд хууль эрх зүйн сурталчилгаа явууллаа. Хуулийн 10 нэр төрлийн сургалтыг давхардсан тоогоор 876 иргэнд хүргэлээ. Төвийн 5 багийн Нээлттэй мэдээллийн өдөр арга хэмжээнд хуульч өмгөөлөгчдийн холбооны өмгөөлөгчид, ГБХЗХГазрын мэргэжилтнүүд, Нийгмийн даатгалын хэлтэс оролцож, 300 гаруй иргэдэд холбогдох хууль сурталчилж иргэдтэй уулзлаа. | |
| | 10 | 1.2.3.Иргэдийн оролцоотой Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, бүх шатанд авлигаас ангид ,ашиг сонирхлын зөрчилгүй ил тод байдлыг хангана. | 2016-2020 | | Авилгын эсрэг үйл ажиллагаан ы төлөвлөгөөн ий хэрэгжилтий н үнэлгээ ахисан байна. | Сумын Авлигатай тэмцэх хөтөлбөрийг ЗД-ын А/29 тоот захирамжаар батлуулж, цахим хуудас, самбарт байрлуулж сурталчиллаа. Хөтөлбөр 90. 5 хувьтай хэрэгжлээ.<br>ХАСХОМ гаргах 45 албан тушаалтны мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулан баталгаажуулж, цахимд байршууллааОдоогийн байдлаар 3 албан хаагчийн ХАСУМэдүүлгийг Авилгатай тэмцэх газарт хянуулж, дүгнэлтийг авч албан тушаалд томиллоо.ХАСХОМэдүүлгийг 2 албан хаагч 30 хоногийн дотор гарган баталгаажууллаа. ЭБАТушаалтны цэсний бүртгэлд тухай бүр хууль,журмын дагуу бүртгэлээ.Авилгын эсрэг өдөрт зориулан ЕБСургуулийн ахлах ангийн 177 сурагчдад хуулийн мэдээлэл,мэдлэг сорих тэмцээнийг сургуулиуд явууллаа. | 100 |
| | 11 | 1.2.4.Байгууллага бүрийн архивын баримтын хадгалалт хамгаалалтыг стандартын шаардлагад нийцүүлж , эрэлт хайлт , тоо бүртгэл мэдээллийн цахим сан байгуулна. | 2016-2020 | | Архивын баримт бичгийн хадгалалт хамгаалалт сайжирна. | Харъяа байгууллагын архивын баримтыг хадгалах, хамгаалах, стандартын талаар сургалт зөвлөмжийг тухай бүр тушаал, албан бичгийг үзэж зөвлөмж хүргүүллээ. Байгууллагын батлагдсан бүртгэлийг байгууллагын архивын ORGAMS программд шивж захирамж, тушаалуудыг скайнердаж 2009-2017 оны баримтыг цахимжуулж байна. Архивын мэдээг хугацаанд нь төрийн архивт хүргүүллээ. | 100 |
| | 12 | 1.2.5.Мэргэжлийн байгууллагатай хамтран иргэдийн оршин суух | 2016-2020 | | Хаягийн зөрчилгүй болно. | Улсын бүртгэлийн байгууллагатай хамтран баг хооронд хүүхэд-233, том хүн-190, иргэний шилжилт хөдөлгөөнийг хийж, нийт 423, 16 настай-226, 25 настай-314, 45 настай-173 , иргэний бичиг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хаягийн мэдээллийн зөрчлийг арилгана. | | | | баримтаа үрэгдүүлсэн-214 нийт 927 иргэнд цахим үнэмлэх олгож, хаягийн зөрчил арилгах ажлыг зохион байгууллаа. | |
| | 13 | 1.2.6.”Хамтдаа шийдье”арга хэмжээг зохион байгуулна. | 2016-2017 | | Төрийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоо нэмэгдэнэ. | “Хамтдаа шийдье” арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгууллаа. Сар бүр тодорхой салбарын иргэдийн төлөөлөлтэй хэлэлцүүлэг хийлээ. Ахмадууд, сургууль, багийн нийгмийн ажилтнууд , Хамтын ажиллагаа түншлэлийн жилийн хүрээнд төр хувийн хэвшлийн уулзалт , Газар тариалан эрхлэгч , Төрийн үйлчилгээний албан хаагчдын сургалт ,ХБИ-ийн уулзалт, СХСангаас зээл авсан иргэдийн сургалт хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, сумын удирдлагууд, мэргэжилтэн нар сум орон нутгийн цаг үеийн мэдээллийг танилцуулж , цаашид хэрхэн хамтран ажиллах , тулгамдаж буй асуудал , тэдний санал хүсэлтийг нь сонслоо. Арга хэмжээнд 900 гаруй иргэн оролцлоо. | 100 |
| **1.3.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх** | 14 | 1.3.1.ГХУСэргийлэх ажилд иргэд, төрийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулна. | 2016-2020 | | Иргэдийн гэмт хэрэг буурна. | Гэмт хэрэг зөрчилгүй баг аяныг зохион байгуулж, төвийн 5 баг ГХУСэргийлэх ажлын төлөвлөгөө гарган иргэд хэсгийн төлөөлөгч нартай хамтран олон нийтийн эргүүлийг 7 хоногт 2 удаа гаргалаа.Сумын хэмжээнд 58 архины хамааралтай иргэдийн судалгааг гаргаж “Говийн хийморь” АА бүлгийн 2 удаагийн уулзалт цуглаанд 16 иргэнийг хамруулдлаа. Одоогоор 5 иргэн тус бүлэгт идэвхитэй хамрагдаж бусдадаа нөлөөлөх ажлыг хийлээ. | 100 |
| | 15 | 1.3.2.“Архигүй Дундговь”, хөтөлбөрийг хэрэгжүүлж, архидалтгүй орчин бүрдүүлэхэд иргэдийн хяналт,үйл ажиллагааг дэмжинэ. | 2016-2020 | | Хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | “Архидалгүй аймаг-Дундговь” дэд хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан нутгийн шийдвэр гаргагчдын дунд “Хандлагаа өөрчлөх” сэдэвт лекцийг МУСГЗ Ж.Цогтсугир хийж,сумын харьяа байгууллагын удирдлагууд,аймгийн төрийн байгууллагын албан хаагчид хамрагдлаа. Иргэд, залуучуудтай хийсэн нэгдсэн уулзалтаар “Архидалгүй аймаг-Дундговь” (2018-2020) дэд хөтөлбөрийг танилцуулж , “Архигүй амьдрал аюулгүйн баталгаа” соён гэгээрүүлэх лекц яриа таниулга хийж, нийт 102 иргэд , залуучууд оролцлоо. ЕБСургуулийн ахлах ангийн нийт 438 сурагчдад лектор сургагч багш С. Батсайхан лекц уншлаа. | 100 |
| | 16 | 1.3.3.Гэр бүлийн хүчирхийлэл тэй тэмцэх, хүүхдийг гэмт хэрэг,осол зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд бүх шатны төрийн болон | 2016-2020 | 2,500,000 | Гэр бүлийн хүчирхийлэл тэй тэмцэх, хүүхдийг ослоос сэргийлэх арга | Сургуулийн нийгмийн ажилтнууд Өсвөрийн цагдаа бүлгэмийн хүүхдүүд, Хүүхдийн байцаагчтай хамтран Замын осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр эцэг эхчүүд, сурагчид, жолооч, багш ажилчдад сургалт ,сурталчилгааны ажлыг төрөл бүрийн хэлбэрээр зохион байгууллаа. Сургууль, цэцэрлэгийн орчинд хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “school police” эцэг эхийн эргүүлийг тогтмол гаргаж байна. Аймгийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ТББайгууллага, эцэг, эх, асран хамгаалагчийг татан оролцуулж,үүрэг хариуцлагыг сайжруулна. | | | хэмжээг зохион байгуулна. | төвийн авто замд явган хүний гарцын 15 тэмдэг, тэмдэглэгээг байршуулллаа. Дэлхийн зөн ОНХХ, Цагдаагийн газартай хамтран бага насны хүүхдийг замын хөдөлгөөнд аюулгүй оролцох хамгаалалт бүхий ханцуйвчийг 1-5-р ангийн 1752 сурагчдад олголоо. Зам тээврийн осолд хүүхэд өртөж байгаа шалтгаан нь жолооч нар машин согтуугаар барих, утсаар ярьж анхаарлаа сарниулах, хурдтай явах зэргээс хүүхэд хохирч байгааг анхааруулсан нөлөөллийн үйл ажиллагаа Тэмүүлэл СОУЗ-ийн сурагчид зохион байгуулж, ЭДЦС-ийн зүүн замаар зорчигч 30 жолоочид анхааруулга санамжийг уншуулллаа. | |
| | 17 | 1.3.4.Сумын цагдаагийн төлөөлөгч,цагдаагийн байцаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлж,иргэдэд шуурхай үйлчилгээ хүргэх боломжийг нэмэгдүүлнэ. | 2016-2020 | 151.900 | -ажиллах нөхцөл сайжирна | Цагдаагийн кабоны засварт дэмжлэг үзүүллээ.Цагдаагийн байцаагч , төлөөлөгч багийн нийгмийн ажилтнуудтай хамтран Жаргалтай гэр бүл аян , Хот тохижуулах газар, байгаль орчны байцаагчтай хамтран орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд хорихоос өөр төрлийн ялтай 10 иргэнд сургалт зохион байгуулж ,модны нүх ухах ажил, сургууль төгсөгчдийн Эрдмийн баяр , Хүүхдийн баярын Дугуйн уралдааныг хамтран зохион байгууллаа. Тусгай зөвшөөрөлтэй ААНэгжүүдэд хяналт шалгалт хийхэд тогтмол хамтран ажиллалаа.Сумын ЗДТГазраас цагдаагийн төлөөлөгчийн үйл ажиллагаанд 205 л шатахуун , бичгийн цаас 8 боодлыг олгоод байна. | 100 |
| | 18 | 1.3.5.Мал сүргийг хамгаалах,мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх,урьдчилан сэргийлэхэд чиглэсэн малчдын бүлэг,нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжинэ. | 2016-2020 | | -Малын хулгай буурна | Сумын ГХУСЗөвлөл, БИНХурлын дарга нар хөдөөгийн 4 багийн малын хулгайтай тэмцэх бүлэглэлтэй хамтран ажиллаж , ГХУСЗөвлөл, Далай багийн нутагт Гэмт хэрэг зөрчилгүй аюулгүй орчин аяны хүрээнд өдөрлөг зохион байгуулж, малын хулгайн талаар мэдээлэл хийлээ. Өдөрлөгт 500 гаруй малчин иргэд оролцлоо. Дэрэн суманд болсон малын хулгайтай тэмцэх зүүн бүсийн зөвлөгөөнд 8 малчин оролцууллаа. Далай багт малын хулгайтай тэмцэх 5, Үйзэн багт 3, Наран багт 7 нөхөрлөл байдаг.Сумын хэмжээнд Тэвш багийн нутаг “Ихэрийн хөндий”-д малын хулгайн 1 тохиолдол гарч , гэмт хэргийг бүрэн илрүүлж хохирогчийг хохиролгүй болголоо. | 100 |
| | 19 | 1.3.6.Хорихоос суллагдсан ажилгүй иргэдийг бүртгэлжүүлж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамруулж түр | 2016-2020 | | Иргэдийг нийгэмшүүлэх ажил явагдана. | Хорихоос суллагдсан ажил хөдөлмөр эрхлээгүй 3 иргэн байна. Эргээр иргэдийн 1 нь хуулийн дагуу орон гэртэй боллоо. Иргэдээс хөдөлмөр эрхлэж байгаа иргэн байхгүй байна. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | болон байнгын ажлын байранд зуучилна. | | | | | |
| 1.4.Батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх | 20 | 1.4.1.Батлан хамгаалах хууль тогтоомжийг иргэдэд сурталчилан хэрэгжүүлж,хяналт тавина. | 2016-2020 | | Шинээр гарсан хуулийн хэрэгжилт хангагдана. | Цэрэг татлагыг жилд 2 удаа явуулж, цэргийн насны нийт 520 иргэнийг хамруууллаа. Ихэнх цэргийн насны залуус өвчнөөр чөлөөлөгдөж байна. Цэргийн насны 450 гаруй залууст Цэргийн тухай хууль танилцуулж, цагдаагийн хэсгийн байцаагчтай хамтран "Зөрчлийн тухай хуулиар сургалт мэдээлэл хийлээ.Иргэдийн эрүүлжүүлэх арга хэмжээг сумын 3 өрхийн ЭМТөвүүд нэрсийн дагуу зохион байгууллаа.<br>Харьяа байгууллагын цэргийн насны эрэгтэйчүүдийн судалгааг гаргууллаа. Судалгаанаас үзвэл цэргийн насны иргэдийн 30 % нь цэргийн жинхэнэ алба хаасан иргэд байна. Багш нарын ихэнх хувь нь мөнгөн төлбөрөөр цэргийн албыг хаалаа. Сумын төвд үйл ажиллагаа явуулж байгаа ААНэгж байгууллагын батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалган 23 иргэнд мөнгөн төлбөр ногдууллаа. | 100 |
| | 21 | 1.4.2.Дайчилгааны төлөвлөгөөг тодотгон, дайчилгааны нөөцийн бүрэлдэхүүний сургалтанд иргэдийг хамруулна. | 2016-2020 | | Бэлтгэл сургалтанд хамруулна. | Дайчилгааны бэлтгэл нөөцийн сургалтанд цэргийн штабаас ирүүлсэн хяналтын тооны дагуу 20 иргэнийг өөрийн аймаг болон Өмнөговь аймгийн цэргийн ангид сургалтанд хамрууллаа. | 100 |
| | 22 | 1.4.3.Гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургуулийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ. | 2016-2020 | 155.000 | Бэлэн байдлын хангалтын үнэлгээ | Сумын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг шинэ дүрмийн дагуу тодотгол хийж,томилгоожуууллаа. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулж. сайн үнэлгээ авлаа. Сумын онцгой комисс,мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн оролцож, аймгийн Улаан загалмайн хорооноос анхан шатны тусламжийн сургалтыг хийлээ. | 100 |
| **ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭНД**<br>***Зорилго: Эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, "Шилэн данс"ны хуулийг бүх шатанд хэрэгжүүлнэ.*** | | | | | | | |
| 2.1.Эдийн засгийн тогтвортой | 2 | 2.1.1.Суманд ашиглалтгүй байгаа төрийн өмчийн барилгын тоог гарган эдийн засгийн эргэлтэнд оруулах,хөрөнгөөс хасах ажлыг хуулийн дагуу зохион байгуулна | 2016-2020 | | Хөрөнгийн хамгаалалт сайжирна. | Тайлант онд хөрөнгийн дахин үнэлгээний ажил орон даяар хийгдэж байна. Орон нутгийн өмчийн газраас ирсэн албан тоот, удирдамжийн дагуу хөрөнгийн дахин үнэлгээ хийгдэж байна. Хагас жилийн тайлангаар ангилал зөрүүтэй хөрнгүүдийг залруулан бүртгэлд тусгалаа. Байгууллагын өмч хамгаалах комиссын дүгнэлтээр хуримтлагдсан элэгдлээ үлдэх өртгөөрөө бүрэн нөхсөн 0 үлдэгдэлтэй хөрөнгөнд үнэ тогтоож шийдвэр гаргууллаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2 | 2.1.2.Газар ашиглалтыг сайжруулж, газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулна. | 2016-2020 | | Газрын хяналт, ашиглалт сайжирна | Худалдаа, үйлчилгээний зориулалтаар 5 иргэнд 0,36га, ШТС-ын зориулалтаар 1 иргэн, 2 ААН-д 0,86га газрыг,үйлдвэрлэл, технологийн зориулалтаар 2 ААН-д 628,9 га шинээр эзэмшүүллээ, Засаг даргын 2018 оны А/126 тоот захирамжаар газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг зарласан боловч оролцогч бүртгүүлээгүйгээс хаагдсан байна. | 70 |
| | 3 | 2.1.3.Мандалговь хотын ерөнхий төлөвлөгөөг шинэчилж батлуулна. | 2016-2020 | | | Аймгийн ИТХ-хурлаар хэлэлцүүлж, 22 тоот тогтоол гарлаа. Хотын ерөнхий төлөвлөгөөг хүлээн авах ажлын комисс байгуулагдлаа. | 40 |
| | 4 | 2.1.4.Банк болон бусад байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлж,уялдаа холбоог сайжруулна. | 2016-2020 | | 480.0 | Төрийн банктай хамтран бодлогын хүү, цалингийн зээлийн хүүгийн өөрчлөлтийн талаар ярилцлага зохион байгууллаа. Ярилцлагад 48 албан хаагч оролцлоо. Хас банк , Төрийн банктай хамтран Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Дугуйн уралдаан, Бүтэн өнчин хүүдэд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнүүдийг хамтран зохион байгуулж дэмжлэг үзүүллээ.“Хамтын ажиллагаа-түншлэл”-ийн жилийн хүрээнд “Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа” хэлэлцүүлгийг төрийн байгууллага,ААНэгжийн захирал, иргэний төлөөллийг хамруулан /50/ СЭЗДСургууль, ХХҮГ-тай хамтран зохион байгууллаа. | 100 |
| **2.2.Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах** | 5 | 2.2.1.Төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэн,өр авлагагүй ажиллана. | 2016-2020 | | -бйагууллага бүр өр, авлагагүй ажиллана. | Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн цахим сүлжээний Freebalance программ ашиглан төрийн сан үйл ажиллагаагаа явууллаа. 2018 онд харъяа төсөвт 15 байгууллагын 68 дансаар нийт **6621** ш төлбөрийн хүсэлтээр 8,228,259.0 мян төгрөгний гүйлгээ шивж гүйцэтгэж, хянан баталгаажуулж дамжууллаа. Сумын 2018 оны орон нутгийн орлогын эхний үлдэгдлийг ЗДТГазрын төсөвт, тусгай зориулалттай шилжүүлгийн байгууллагын сангуудын оны эхний үлдэгдэл 20,3 сая төгрөгийг нэмэгдүүлэн , төсөвт нэмэлт өөрчлөлт оруулан ИТХ-ын 7 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан. Зайлшгүй үүсэх өрийн судалгаа гарган төсөвт зохицуулалт хийх саналыг Аймгийн санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлж, оны эцсээр өр үүсэхгүй, авлагыг бууруулсан. | 100 |
| | 6 | 2.2.2.Төсвийн зарцуулалтанд тавих хяналт, үнэлгээг иргэд, ТББайгууллагаар | 2016-2020 | | Мэдээллийн ил тод байдал хангагдана. | Төсвийн ерөнхийлэн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан аудитлагдаж зөрчилгүй санал дүгнэлт авлаа. Тус тайланг харъяа төсөвт 15 байгууллага, 7 сангийн санхүүгийн тайланг нэгтгэлээ.Шилэн дансны хуулийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | гүйцэтгүүлнэ. | | | | хэрэгжилтэд аймгийн аудитын газар, санхүүгийн дотоод хяналтаас хяналт шалгалт хийж, хэрэгжилт 98 хувьтай байна. | |
| | 7 | 2.2.3. Байгууллага бүрийн Шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж, төсвийн шууд захирагч,нягтлан бодогчдын ажлын хариуцлагыг сайжруулна. | 2016-2020 | | -санхүүгийн ил тод байдал хангагдана | Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төсвийн мэдээллээ хуулийн хугацаанд байршуулж илгээлээ. 1-3-р улирлын сумын нэгтгэсэн тайлангаар 95 хувьтай. Байгууллага бүрийн мэдээллийн санг хянан, заавар зөвлөмжийг тухай бүр өгч ажиллалаа. Төсвийн нягтлан бодогч нарт сургалт,мэдлэг сорих тэмцээнийг сумын санхүүгийн албанаас явууллаа. | 100 |
| | 8 | 2.2.4.Татварын орлогын төлөвлөгөөг жигд биелүүлэхэд ТАХаагчдын ажлын уялдаа,хариуцлагыг нэмэгдүүлнэ. | 2016-2020 | 120,732.4 | татварын орлого биелнэ. | ОНО –ын төлөвлөгөө 11 сарын мэдээгээр 403,191.0 мянган төгрөг, гүйцэтгэл 456,453.6 мянган төгрөг 113.2 хувийн биелэлттэй.Багийн засаг дарга нартай галт зэвсэг, бусад татвар төлөлтийн талаар мэдээлэл солилцож, үлдэгдэл татварыг төлүүллээ. Үүнд галт зэвсэг 3075.0 , түгээмэл тархац 8.820,0 бусад орлого 3.426.3 нийт 15,321.3мян төгрөгийн орлого ОНО-д төвлөрүүллээ. Аймгийн цагдаагийн хэлтэстэй хамтран 11,12 сард “Галт зэвсэг -2018” аян зохион байгуулж 12 сард бууны албан татварыг 100% төвлөрүүллээ. | |
| **ГУРАВ.НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**<br>***Зорилго:Иргэдийн эрүүл аюулгүй орчинд сурч, хөгжих, ажиллаж ,амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн үйлчилгээнд тэгш хүртээмжтэй хамрагдах боломжийг бий болгох замаар хүний хөгжлийг дээдэлнэ*** | | | | | | | |
| **3.1. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах** | 1 | 3.1.1.Иргэдийг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамруулж, В,С вирусийн илрүүлэлт, эмчилгээг сайжруулж, зонхилон тохиолдох хавдрын өвчлөлийг бууруулна. | 2016-2020 | | Урьдчилан сэргийлэх үзлэг хийгдсэн байна. | Элэг бүтэн монгол “ хөтөлбөрийн 2-р шатны үйл ажиллагааны хүрээнд 15-39 насны 1050 иргэдхамрагдахаас 663 иргэд хамрагдлаа. В вирустэй 39 буюу 5,8 %, С вирутай 20 буюу 3,0 % илэрснийг аймгийн нэгдсэн эмнэлэгт илгээж В.С вирусын өөрчлөлтэй иргэдийг халдвартын эмчийн хяналтад үзүүллээ. | 70 |
| | 2 | 3.1.2.Эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”ийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан, | 2016-2020 | | -Өвчлөл буурна.<br><br>- Хүүхэд бүр хамрагдсан байх | 2018 оны 12 сарын байдлаар 132 эх амаржсан ба 72 цагийн дотор 100 % эргэлт хийлээ.<br>2017 оны жилийн эцсийн хүн амын статистик тоогоор 5 хүртэлх насны нийт 837 хүүхдээс давхардсан тоогоор 1518 хүүхдийн өсөлт жинлэлт хийсэн байна.<br>Өсөлтийн хоцрогдолтой хүүхэд байхгүй.<br>Хүүхэд болон эхийн эндэгдэл гараагүй | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хүүхдийн өвчлөлийг бууруулна. | | | | | |
| | 3 | 3.1.3.Сумын ЭМТөвийн гамшиг осол,шинэ сэргэж буй халдварын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлын нөөцийг бүрдүүлнэ. | 2016-2020 | | Бэлэн байдал хангагдана | Гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөө, шүлхий өвчний үед хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, гамшгийн бэлэн байдлыг хангах зорилгоор 1 удаагийн хамгаалалтын комбинзон 10 ариутгалын уусмал зэрэг бэлтгэсэн байна. Сумын хэмжээнд гарсан ариутгалын постуудад өдөр бүр үзлэг хийж витаминжуулалт хийлээ.<br>Бэлэн байдлын нөөцийг журмын дагуу бүрдүүллээ. | 100 |
| | 4 | 3.1.4.Цахим эрүүл мэндийн төслийг хэрэгжүүлнэ. | 2016-2020 | | иргэдэд жигд хүртээмжэй, хурдан шуурхай үйлчилнэ. | Сумын ЭМТөв Нийгмийн даатгалын газраас цахим жор бичилтийн талаар сургалт авч хөнгөлөлттэй эмийн жорын үйлчилгээг иргэдэд жигд хүртээмжэй, хурдан шуурхай үзүүлэх үүднээс онлайн үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж байна. SPSS судалгааны программ суулгаж НЭМА –г 2 хоногийн сургалтанд, Нарлаг багийн их эмчийг 2 өдрийн ЭХО-ны баримжаа олгох сургалтанд хамрууллаа. Дархлаажуулалт цахим програмд шилжиж байгаатай холбоотой дадлагажуулах сургалтанд хамрагдлаа. | 100 |
| | 5 | 3.1.5.Сумын ЭМТөвийг зүрхний цахилгаан бичлэг, зөөврийн ЭХО аппаратыг тогтмол ажиллуулна | 2016-2020 | | Иргэдэд чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлнэ | Сумын ЭМТөв Нарлаг багийн их эмч Я.Цэнд-аюуш ЭХО -ны баримжаа олгох сургалтанд хамрагдаж жирэмсний эхний 3 сартай ээжүүдэд ЭХО-гоор харж үйлчилж байна. | 100 |
| | 6 | 3.1.6.Сумын ЭМТөвд авто машины парк шинэчлэлт хийж, бага эмчийн унааны асуудлыг шийдвэрлэнэ. | 2016-2020 | 2,997300 | Авто машины парк шинэчлэл хийгдэнэ. | 2018 оны 1-р улиралд Эрүүл мэндийн яамнаас УАЗ-2206 маркийн ДУА 52-18 дугаартай пургон машин хүлээн авсан. Пургон машины доторлогоо бэхэлгээнд 2 сая төгрөг зарцуулж, граж шинээр барилаа. | 70 |
| | 7 | 3.1.7. Шинэ суурьшлын хороололд усан санг бий болгоно. | 2016-2020 | 13,0 сая | Ундны усан хангамж нэмэгдэнэ | Засаг даргын А/91 тоот захирамжийн дагуу усан сан бий болгох үнэлгээний хороо байгуулагдан тендерийг зарлан Мандал багийн 17-р гудамжинд 300 м шугам бүхий ус түгээх байр барих ажлыг ОНХСангийн хөрөнгөөр “Дундговь-Ус” ОНӨААТҮГазар гүйцэтгэлээ. Тус ус түгээх байр нь Мандал багийн иргэдийг ундны усаар хангах зорилгоор баригдсан бөгөөд Мандалын 16-р гудамжнаас урагш амьдардаг өрхүүд ойр цэгээс ундны усаа хэрэглэх боломжтой болж, 300 м шугам дагуу амьдардаг айлууд цэвэр усны шугамд холбогдох боломж бүрдлээ. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 8 | 3.1.8.Иргэдийн усыг зохистой хэрэглэх, ашиглах боломжийг бүрэн шийдвэрлэх арга хэмжээ авч гадаадын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжийг судална. | 2016-2020 | | Усыг зохистой хэрэглээ нэмэгдэнэ. | Иргэдэд усны эрүүл ахуйн 7 дадал хуванцар савны хэрэглээний тухай гарын авлага боловсруулж аймгийн төвийн 15 худаг дээр байрлуулллаа. Мөн гэр хороололд оршин суудаг 40 иргэдэд Ундны усны чанар,зөв хооллолтын аюулгүй байдал,эрүүл ахуй сэдэвт сургалтыг МХГ-ын мэргэжилтэнтэй хамтран хийлээ.Тус сумын Арвижих багийн нутагт байгаа “Сайн ус” ны худагт шинжилгээ хийлгэж, хашаажуулах арга хэмжээ авлаа. | 70 |
| | 9 | 3.1.9.Төрийн болон ТББайгууллага,хувийн хэвшил,иргэдийн идэвхи оролцоог нэмэгдүүлэн “Эрүүл хот”, сум, баг, байгууллага, өрх, иргэд”ийг шалгаруулна. | 2016-2020 | | ТББайгууллага,хувийн хэвшил, иргэдийн идэвхи оролцоо нэмэгдэнэ | "Эрүүл мэндийг дэмжигч өрх "шалгаруулах уралдааныг 12 үзүүлэлтийн дагуу явуулж болзол хангасан өрхүүдийг шалгаруулллаа. "Эрүүл мэндийг дэмжигч өрх”-өөр<br>1. Наран багийн иргэн Г. Дугар<br>2. Тэвш багийн иргэн Б. Нэргүй<br>3. Далай багийн иргэн М. Чулуу<br>4. Үйзэн багийн иргэн Л. Нямзав | 100 |
| | 10 | 3.1.10.Хөдөөгийн малчдыг эрүүл мэндийн УС-х үзлэгт хамруулна. | 2016-2020 | | Малчдын эрүүл мэнд сайжирна | Нийт хөдөөгийн 6687 малчдыг үзлэгт хамруулснаас 2870 буюу 42,9 %-ийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамрууллаа. | 70 |
| | 11 | 3.1.11.Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох,мэдээлэл, сургалт, сурталчилгааг тогтмолжуулж, эрүүл зан үйл, хандлага, дадлыг төлөвшүүлэх, тэдний санал санаачлагыг дэмжинэ. | 2016-2020 | | Эрүүл мэндийн боловсрол нэмэгдэнэ | МХГ-ын эрүүл ахуйн халдвар хамгааллын улсын ахлах байцаагчтай хамтран сургууль, цэцэрлэгийн эмч, тогооч, үйлчлэгч нийт 43 албан хаагчид “Сургуулийн орчинд эрүүл зөв хоол бэлтгэх, эрүүл ахуйн дэглэм сахих нь” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтаар СЭМТ-өөс 2, МХГ-аас 3 бүлэг хичээл заалаа. Сургалтын үр дүн: Цаашид эрүүл ахуйн дэглэм сахих, сургуулийн орчинд хүүхдүүдэд хоногийн хоолны орц нормыг зөв тогтоох, хоол хүнсээр дамжих халдварт өвчний талаар зохих мэдээлэлтэй боллоо. | 100 |
| | 12 | 3.1.12.Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн хувийг сумын хэмжээнд нэмэгдүүлэхэд хамтарсан багийн үйл ажиллагааг дээшлүүлнэ. | 2016-2020 | | Халдварт бус өвчин эрт илэрнэ | Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгээр: Артерийн гипертинзи үзлэгт 1049 иргэн хамрагдахаас 591 буюу 56,3 % Чихрийн шижин үзлэгт 1120 хамрагдахаас 600 буюу 53,7 %, Хөхний үзлэгт 822 хамрагдахаас 565 буюу 68,7 % ,Умайн хүзүүний хавдар илрүүлэх эсийн шинжилгээнд 298 хамрагдахаас 221 буюу 74,1 хамрагдаад байна. | 70 |
| | 13 | 3.1.13.Иргэдийн дунд БЗДХӨ-ний өвчлөлийг бууруулах ажлыг зохион байгуулна. | 2016-2020 | | Өвчлөл буурна | Сүрьеэ өвчнөөр 2017 онд 10, 2018 онд 6 тохиолдол бүртгэгдлээ. Хөдөөгийн хүн амд сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварын илрүүлэг үзлэг шинжилгээ, оношилгоог хийх төслийн хүрээнд “Сүрьеэгүй ирээдүйн төлөө хамтдаа -1” “Эрүүл цус-2” аяны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүрээнд нийт 223 иргэнийг хамруулж 26- ийг цэрний сорьцыг авахуулахаар явуууллаа. “Сүрьеэгүй Дундговь” сэдэвт сургалтанд 1 их эмч 3 бага эмч 2 сувилагч хамрууллаа. | |
| | 14 | 3.1.14.Сумын цэцэрлэгүүдийг эмчтэй болгох асуудлыг шийдвэрлэнэ. | 2016-2020 | | Эрүүл мэндийн үйлчилгээ ойртоно | 2017-2018 онд сумын 7 цэцэрлэгийн 1 цэцэрлэг бие даасан эмчтэй болж, 6 цэцэрлэг гэрээт эмч ажиллуулан хүүхдэд эрүүл мэндийн үйлчилгээг хүргэлээ. ЭМГазраас 1653 хүүхдийг цагаан хорхойн шинжилгээнд хамрууллаа. Сумын 5 сургууль, 7 цэцэрлэгийн нийт 4343 хүүхийг амны хөндийн эрүүл мэндийн үзлэгт хамруулж шүдний өвчлөлтэй 1613, эрүүл шүдтэй 1359 хүүхэд байна. Эмч нар хүүхдүүдийг витаминжуулан , вакцинжуулалтын судалгаа гарган үр дүнг тооцлоо. Дэлхийн гар угаах өдрөөр эцэг эхчүүдэд Гар угаахын ач холбогдол сургалтыг зохион байгууллаа. | 100 |
| 3.2. Боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх | 15 | 3.2.1.Хүүхдийг иргэн болгон төлөвшүүлэхэд эцэг, эхийн хяналт, оролцоог нэмэгдүүлнэ. | 2016-2020 | | Эцэг эхийн оролцоо нэмэгдэнэ | Сумын “хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсооход эх дэлхийгээрээ нэгдье” аяны хүрээнд ЕБоловсролын 5 сургуулийн багш, сурагч тэдний асран хамгаалагчдад сургалт хэлэлцүүлгийг аймгийн ГБХЗХГазар, сумын ЗДТГазрын нийгмийн ажилтан, сургуулийн нийгмийн ажилтан хамтран зохион байгууллаа.<br>Аянд 1980 суралцагч, 638 эцэг эх асран хамгаалагчид нийт 2618 иргэн хамрагдлаа. ЭДЦС, ГИЦС, Хүмүүнлэг сургууль, 7 цэцэрлэг эцэг эхийн SHOOL POLICE эргүүлийг ажиллуулж нийт 2484 эцэг эх хуваарийн дагуу гарч, зам тээврийн хөдөлгөөнийг зохицуулан хүүхдийн аюулгүй байдалд анхаарлаа. | 100 |
| | 16 | 3.2.2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын багш нарт зориулсан”Багш бүрт компьютер” хөтөлбөр хэрэгжүүлнэ. | 2016-2020 | | Багш нарын ур чадвар дээшилнэ. | БСШУСЯ-наас 1-р цэцэрлэг, 4-р цэцэрлэг, 6-р цэцэрлэгт 4 ширхэг компьютер, өнгөт принтер 2-ыг олголоо. Мөн 1,2,3,4,5,6,7, цэцэрлэгүүд дотоодын нөөц бололцоог ашиглан хандивын шугамаар багш нарын компьютерын хэрэгцээг хангалаа | 100 |
| | 17 | 3.2.3.Сургуулиудыг байгаль , нийгмийн ухаан, гадаад хэл, урлаг,спортын төрөлжсөн ангитай болгоно. | 2016-2020 | | Төрөлжсөн сургуулиуд нэмэгдэнэ. | Үнэлэх боломжгүй | -- |
| | 18 | 3.2.4.Мандал сургуулийг “Цахим сургууль” хөтөлбөрт хамруулж, стандартад нийцсэн орчин | 2016-2020 | | Хөтөлбөр хэрэгжинэ. | Мандал сургууль 155.0 сая төгрөгний төсөвтэй “Цахим сургууль” төслийг боловсруулан аймгийн Засаг дарга болон БСУГ-талбан бичгээр хүргүүллээ. | 40 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | үеийн техник хэрэгслээр бүрэн хангана. | | | | | |
| | 19 | 3.2.5.Ахмад настан, залуучууд ,хүүхдийн гурван үеийн алтан хэлхээг бэхжүүлэх ажлыг монгол ёс уламжлалд тулгуурлан хэрэгжүүлнэ. | 2016-2020 | | Ахмад үеэсээ суралцана. | Сургалтын МУГБ, зөвлөх багш, профессор З.Цэвээравдан "Ахмадын зөвлөх үйлчилгээ авах төслийн дагуу" "Эрдмийн далай" цогцолбор сургуулийн 10-11-р ангиудад 137 цагийн зөвлөн туслах сургалтыг 245 сурагчдыг оролцуулан явууллаа. Дундговь аймгийн "Ахмад болон тэргүүлэх мэргэжлийн зэрэгтэй багш нар"-ын анхдугаар зөвлөгөөнд тус сумаас гарсан гавьяат багш Д.Дамдинжав, Г.Бизъяажав, З. Цэвээнравдан нар оролцлоо. Уг зөвлөгөөнд ЕБСургуулийн багш нар "Багшийн арга туршлага" үзэсгэлэн гаргаж, Зөвлөх багш Ц.Ганхуяг, тэргүүлэх зэрэгтэй багш Т.Мөнхбат нар илтгэл тавилаа. | 100 |
| | 20 | 3.2.6. "Хүүхдэд ээлтэй дотуур байр" хөтөлбөр хэрэгжүүлнэ. | 2016-2020 | 126.6 сая | Тав тухтай орчин бүрдэнэ | Хөтөлбөрийн хүрээнд ЭДЦСургуулийн 2 дугаар дотуур байр нь гадаа орчноо тохижуулан, ногоон байгууламжаа томруулж, зүлэгжүүлж,тохижилт хийлээ.Аймгийн ОНХСангийн хөрөнгөөр дотуур байрны дээврийн засвар, сантехникийн засварыг "Ган-Илч" ХХК хийлээ.<br>ГИЦСургуулийн хүүхдийн дотуур байр нь 17 00-ын өрөөтэй, халуун усны өрөөнд 4 шүршүүртэй, угаалтуур-10, хувцас угаах 3 машинтай.Хяналтын камерыг хоолны зааланд-1, давхруудын коридорт нийлээд-5, шатанд-1, гадна үүдэнд-1 зэргийг байрлуулж ашиглаж байна.Тоглоомын уншлагын танхимд 5 суурин комьпютертэй. 6 настны өрөөг суралцах тав тухтай орчинг бий болгож, зориулалтын 00-н өрөөтэй боллоо. | 100 |
| | 21 | 3.2.7.Багшийн хөгжил, ажлын үнэлэмжийг дээшлүүлж, гадаад дотоодод сургалтанд хамруулах замаар чадварлаг багшийн тоог нэмэгдүүлнэ. | 2016-2020 | | Багшийн чадвар нэмэгдэнэ | Мэргэжлийн багш нарын 1,5,10 жилийн сургалтанд хуваарийн дагуу Улаанбаатар хотод 13 багш хамрагдав.<br>Өвөр монголын Баяннуур аймгийн хамтын ажиллагааны хүрээнд тус сумаас 5 сургуулийн 10 багш 5 хоног Баяннуур аймгийн дунд, бага сургуулиудтай танилцаж, туршлага солилцлоо.<br>2018 онд 63 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1352 багш, ажилчид хамрагдсан байна. Хос тархины тэнцэл төслийн хүрээнд бага ангийн 16 багш, сургалтын менежерийн хамт нийслэл хотод ТОУО академийн сургалтанд хамрагдлаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 22 | 3.2.8. МУ-ын гавъяат багш Н.Өлзийн нэрэмжит улсын математикийн нээлттэй олимпиадыг жил бүр уламжлал болгон зохион байгуулна. | 2016-2020 | 590.0 | Математикийн сургалтын чанар дээшилнэ. | Мандалговь хотноо МУГБ Н.Өлзийн нэрэмжит математикийн нээлттэй олимпиад жил бүр амжилттай зохион байгуулагдаж, Улаанбаатар хот төдийгүй бусад аймгууд болон өөрийн аймгийн нийт 30 сургуулийн төлөөлөл 1000 гаруй багш сурагчид оролцлоо. МУГБ Н.Өлзийн нэрэмжит математикийн олимпиад нь Улаанбаатар хотын багуудыг нээлттэй оролцуулдаг хөдөөгийн ганц олимпиад гэдгээрээ нэр хүнд, чансаа зэрэглэлийн хувьд улсын хэмжээнд 3-рт эрэмбэлэгддэг олимпиад юм. | 100 |
| **3.3.Биеийн тамир ,спортын арга хэмжээнд иргэдийг хамруулах** | 23 | 3.3.1.Хотын төвд хөнгөн атлетикийн болон хөл бөмбөгийн ногоон талбайтай болно. | 2016-2020 | | | Үнэлэх боломжгүй | - |
| | 24 | 3.3.2. Спортын “Бага олимп”зохион байгуулна. | 2016-2020 | | | Дундговь аймгийн "Нэг зорилго-нэг баг" уриатай “Бага олимп” спортын тэмцээнд сумын төв хөдөөгийн багууд 3 багт хуваагдаж амжилттай оролцлоо. Тэмцээнд нийт 201 тамирчид спортын 7 төрлийн 216 багц медалийн төлөө өрсөлдөж нийт 22 медаль хүртлээ. Үүнээс: Алт-10 Мөнгө-9 хүрэл-4 Багийн нийт дүнгээр Наран, Далай, Нарлаг багийн баг тамирчид тэргүүлж, Үйзэн, Арвижих, Айраг багийн баг тамирчид гутгаар байранд шалгаран Цом, өргөмжлөл хүртлээ.Сумын залуучуудын аврага шалгаруулах “Волейбол”ын тэмцээнд төвийн 5 багийн 80 гаруй тамирчид,хөл бөмбөгийн тэмцээнд 6 багийн 60 тамирчин оролцлоо. | 100 |
| | 25 | 3.3.3.Суманд шинээр байгуулагдах спортын холбоо,хамтлагийн үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллана. | 2016-2020 | | | Сумын засаг даргын А/105 захирамжийн дагуу сумын ЗДТГ-ын дэргэд Биеийн тамир, спортын орон тооны бус зөвлөлийг 6 хүний бүрэлдэхүүнтэй байгууллаа. Сумын хэмжээнд үндэсний сур, шагайн харваа,сагсан бөмбөг,волейболын спорт насны ангилалаар түлхүү хөгжиж байна. Цаашид багийн спортыг дэмжих бодлого барин ажиллаж байна. | 100 |
| | 26 | 3.3.4.Биеийн тамираар хичээллэх,хөдөлгөөний хомсдлоос урьчилан сэргийлэх арга хэмжээг багийн иргэдийн дунд байнга зохион байгуулна. | 2016-2020 | 550.0 | Хөдөлгөөний хомсдлоос сэргийлнэ. | Сургуулиудын биеийн тамирын багш нар волейбол, сагсан бөмбөгийн дугуйлан хичээллүүлж сурагчдыг бэлтгэж байна. Улсын чанартай тэмцээн уралдаанаас Волейбол- 26, Сагсан бөмбөг- 1, Жудо-1, Хөнгөн- 5, Таекандо-21 сурагчид амжилт үзүүллээ. Сурагчдын лиг”-2017 сагс, волейбол”-ын тэмцээнийг зохион явууллаа.Сумын төсвийн байгууллагуудын ажилчин албан хаагчдын дунд волейбол-102, сагсан бөмбөг-126 , теннисны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тэмцээн-130, даам-26 нийт 4 төрлийн тэмцээнийг зохион явуулж, давхардсан тоогоор нийт-384 ажилчин албан хаагч оролцлоо.<br>Төвийн багуудын дунд хөл бөмбөг, волейболийн тэмцээн, хөдөөгийн багийн залуучуудын дунд волейболын тэмцээнийг зохион байгуулж, 130 гаруй тамирчид оролцлоо. Бага олимпд багууд нийлж 3 хэсэг болж амжилттай оролцлоо.<br>Монгол улсын ерөнхий сайдын ивээл дор зохион явуулсан Дундговь аймгийн "Иргэдийн спортын наадам"-ын 2-р шатны шигшээ тэмцээн давхардсан тоогоор 282 иргэн хамрагдаж спортын 5 төрлөөр өрсөлдлөө. БТСГ-ын зохион явуулсан графикт 21 тэмцээн уралдаанд ЕБоловсролын 5 сургуулийн 23 багш 644 хүүхэд оролцлоо. | |
| **3.4.Соёл урлагийг хөгжүүлэх** | 27 | 3.4.1. "Дундговь- Дуу хуурын өлгий"соёл урлагийн өдөр, байгууллагуудын дунд урлагийн үзлэг зохион байгуулж, сурталчлахад хамтран ажиллана. | 2016-2020 | | Шинэ авьяатныг тодруулна. | Багш нарын "Урлагийн бага наадамд 6 төрлөөр сургууль цэцэрлэгүүдээс нийт 246 багш , ажилчид оролцож, Тэргүүн байрыг Мандал сургууль, дэд байранд МГССургууль, тусгай байранд ГИЦСургууль шалгарлаа.Багш нарын авьяасыг тодруулах арга хэмжээ боллоо. | 100 |
| | 28 | 3.4.2 Орон нутгийн урлагийг гадаад дотоодод сурталчилах санаачлагыг дэмжиж хамтран ажиллана. | 2016-2020 | 1252.0 | Хамтын ажиллагаа өргөжнө. | Сумын засаг даргаас дараах арга хэмжээг дэмжлээ. Үүнд.: Завхан аймагт болсон 3330 морин хуурчдын тоглолт, ардын хөгжмийн "Ая эгшгийн 6 жигүүр" уралдаан, Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрын авьяаслаг сурагчдын Баянхонгор, Эрдэнэт хотод болсон тоглолт, сурагчдын тайлан тоглолт,малчдын урлагийн бага наадам. | 100 |
| | 29 | 3.4.3.Хүүхэд бүрийн авьяасыг нээн хөгжүүлэх, дуу хөгжим, зураг, техник технологийн хичээлийн тайланг эцэг эх, иргэдэд сурталчилна. | 2016-2020 | 800.0 | Авъяасыг нээн хөгжүүлнэ | Ардын боловсролын тэргүүний ажилтан, ахмад багш М.Алтангэрэлийн нэрэмжит "Залуу зохион бүтээгч" уралдааныг зохион байгууллаа. Уг тэмцээнд 2 насны ангилалд 50 хүүхэд оролцлоо. Сургуулиуд технологи, зураг зүй, физикийн хичээлээр сурагчдыг авъяас чадварыг хөгжүүлж 598 сурагчийг хамруулан, эцэг эхчүүдэд тайлант өдөрлөгийг зохион явууллаа<br>Сумын 7 цэцэрлэгийн дуу хөгжмийн багш нар бүлэг бүрт дуу хөгжмийн хичээлийн дагуу тайлант өдөрлөгүүдийг 3-4 удаа зохион байгуулж эцэг эхчүүдэд танилцуулан , хүүхдийн хөгжилд үнэлгээ дүгнэлт хийлээ. Сумын хэмжээнд 2 бүлэг ТХДЖТ , 6-р цэцэрлэг 5 бүлгийн 160 хүүхдийг хамруулан ТТХТ-т тайлант өдөрлөгийг зохион байгууллаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2 Энэ хичээлийн жилд нийт 48 төрлийн дугуйлан секц хичээллэж, давхардсан тоогоор 3325 сурагч хамрагдсан байна. Дугуйлангаар сурагчдаа хэрхэн хөгжүүлснээ багш болон сурагчид эцэг, эхдээ тайлагнав. Нийтдээ 1621 эцэг эх, олон нийтийг энэ үйл ажиллагаанд оролцуулсан байна.Нийслэл хотод болсон "Ая эгшгийн 6 жигүүр" урлагийн наадамд 5а ангийн ардын хөгжмийн хамтлаг оролцож сурагч Г.Эмүүжин хүрэл медаль хүртлээ. | |
| | 30 | 3.4.4.Түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг хамгаалалтанд авч хадгалалт хамгаалалтыг сайжруулна. | 2016-2020 | | Түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг хамгаална | Сумын хэмжээнд түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газар 44 байдаг. Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 04 дүгээр сарын 25 ны 18 дугаар тогтоолын дагуу иргэдэд харицуулан, хадгалалт, хамгаалалтанд хяналт тавьж байна. | 100 |
| | 31 | 3.4.5."Өрх бүр угийн бичгээ хөтөлцгөөе"аяныг өрнүүлэн,нийт өрхийн 70%-аас доошгүй хувийг угийн бичигтэн болгож, гэрчилгээ олгоно. | 2016-2020 | | Угийн ычичгтний тоо нэмэгдэнэ. | Угийн бичиг хөтөлсөн иргэдийн нэгдсэн судалгааг гаргалаа. Өмнөх онд 280 төрийн албан хаагч , 19778 өрх , 80694 иргэн байсан бол одоогийн байдлаар 154 албан хаагч , 3834 өрх , 7818 иргэн нэмэгдлээ. Нийт 14 иргэнд гэрчилгээ олголоо. | 70 |
| | 32 | 3.4.6.Сургуулиудын номын санд "Цахим номын сан"бий болгоно. | 2016-2020 | | Номын сангийн үйл ажиллагаа тогтмол жино. | Цахим сургууль хөтөлбөр ЭДЦС, ГИЦС, 3-р сургуульд хэрэгжүүлэхээр БСШУСЯ-аас шийдвэрлэлээ. Дэлхийн зөн ОНХХ-ийн санхүүжилтээр ГИЦСургуульд 1950000 төгрөгний 10 ширхэг номын тавиур хүлээн авч номын хадгалалт хамгаалалт сайжирч , МГССургуульд номын фонд нэмэгдүүлэх, суудлын тоог нэмэглүүлэх 1467000 төгрөг, Хүмүүнлэг сургуульд 1245000 төгрөгийн Монгол хэлний тайлбар толь 50 ширхэг номоор тус бүр дэмжлэг үзүүллээ. ЕБ-ын 5 сургуульд цахим номын сангийн MONBIBLIO дрограмм суулгалаа. Уран зохиолын номыг бар коджуулж цахимд шивж оруулж байна. | 100 |
| **3.5. Гэр бүл , хүүхэд** | 33 | 3.5.1."Гэр бүлийн хөгжил,хамгааллыг дэмжих"аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2016-2020 | | | Үнэлэх боломжгүй | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 34 | 3.5.2. Залуучуудын хөгжлийг дэмжсэн уулзалт, сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулна. | 2016-2020 | | Идэвхи оролцоо нэмэгдэнэ | Сумын залуучуудын чуулга уулзалтанд харьяа төсөвт байгууллага, 9 багийн багш, ажилчид албан хаагч, ажил идэвхтэй хайж байгаа залуучууд, хувиараа хөдөлмөр эрхлэгч нарын нийт 129 төлөөлөгчид хамрагдлаа. Чуулга уулзалтын үеэр Хөгжлийн гарц –Миний оролцоо сэдэвт илтгэлийн уралдаан зохион байгуулж, эхний 3 байрыг шалгаруулл аа. Залуучуудын чуулга уулзалтаас ГИЦСургуулийн багш Б.Ууганцэцэгийн “Оролцоотой оюунлаг иргэн орон нутгийн хөгжлийн гарц болох нь” илтгэлийн төслийг дэмжлээ.<br>“Залуу багш нар”-ын зөвлөгөөнд сумын ЕБоловсролын сургуулиас 40 багш оролцлоо.<br>Орон нутгийн залуучуудын салбар нэгжийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх, ажлын уялдаа холбоог сайжруулах, мэдлэг урчадварыг нэмэгдүүлэх зорилгоор сумын залуучуудын бүлгэмийн гишүүдийг чадваржуулах сургалтад цэцэрлэгийн залуу багш нарын Тэмүүлэл бүлгэмийн 4 багш хамрагдлаа. | 100 |
| | 35 | 3.5.3. Сумын залуучуудын холбооны үйл ажиллагааг сайжруулна. | 2016-2020 | | Залуучууды н оролцоо нэмэгдэнэ | Сумын залуучуудын холбоо, төвийн 5 багийн залуучуудын зөвлөл, цэцэрлэгийн залуу багш нарын Тэмүүлэл клуб, залуу багш нарын Хөгжлийн түүчээ зөвлөл тус тус үйл ажиллагаагаа явуулж байна.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг сурталчилах аяны хүрээнд тус сумын 7 цэцэрлэг, 5 сургуулийн нийт 1641 иргэд , хүүхэд, багш, ажилчдадхуулийг сурталчлах ажлуудыг зохион байгуулж гарын авлага тараалаа. Хуулийг бататгах үүднээс алтан хонх, АХА тэмцээнийг зохион байгууллаа.<br>Төвийн 5 багийн Нээлттэй хаалганы өдөрлөгөөр Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг 102 иргэдэд сурталчлан гарын авлага тараалаа. | 70 |
| | 36 | 3.5.4.Салбарын тэргүүний шилдэг залуучуудыг жил бүр шалгаруулна. | 2016-2020 | | Шилдэг багш нарыэ тоо нэмэгдэнэ. | Багш нарын баярыг тохиолдуулан амжилт гаргаж ажилласан 19 багшийг сумын засаг даргын “Жуух бичиг”- ээр шагнаж урамшууллаа. | 100 |
| | 37 | 3.5.5. Сумын хүүхэд хамгааллын бодлогыг боловсруулна. | 2016-2020 | | Хүүхэд хамгааллын асуудал идэвхжинэ. | Сумын хүүхэд хамгааллын төлөвлөгөөг батлуулж нийт заалт 11, биелсэн заалт 11 биелэлтийн хувь 94,5%-тай хэрэгжлээ. Хамтарсан багийг чадавхжуулах 2 өдрийн сургалтад хамтарсан багийн 25 гишүүдийг хамруулж кейстэй ажиллах чадвар, дадлагатай болголоо. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 38 | 3.5.6. Тэргүүний гэр бүл, хүүхдийг алдаршуулах арга хэмжээг зохион байгуулна. | 2016-2020 | 1426.6 | Тоо нэмэгдэнэ | Сумын тэнгэрлэг гэр бүлийг 5 төрлөөр алдаршууллаа. "Оюунлаг гэр бүл "-ээр Дагдан овогтой Галбадрахын гэр бүл /Нарлаг баг / , " Авъяаслаг гэр бүл"-ээр Янжинлхам овогтой Мөнхгэрэлийн гэр бүл / Нарлаг баг / , " Бүтээлч гэр бүл"-ээр Пүвэвдорж овогтой Цэрэндашийн гэр бүл Мандал баг / " Малчин гэр бүл" -ээр Даваа овогтой Эхнэрийн гэр бүл /Арвижих баг / " Өнөр гэр бүл"-ээр Дэндэв овогтой Сосорбурамын гэр бүл /Айраг баг / тус тус тодорлоо.<br>Эрдмийн баярын нэгдсэн арга хэмжээг сумын ЕБС-ийн 5 сургуулийн 9,12-р ангийн 26 бүлгийн 724 төгсөгч, АУБагш нарын дунд зохион байгууллаа. 2017-2018 оны хичээлийн жилд сурлага, урлаг спортын амжилт гаргасан төгсөгч 45 хүүхдэд аймгийн засаг даргын жуух бичиг, Нацагдорж тэмдэгтэн, ХГБЗХХ-ийн авьяас алт мөнгөн медаль, Тэнгэрийн тэмдэг хүүхдийн теартын медалиудаар тус тус шагнууллаа. Сумын ЗДТГазраас хичээлийн жилд урлаг спорт, сурлагаар амжилт гаргасан “Шилдэг 5 төгсөгч” хүүхдүүдийг алдаршуулж цом, дурсгалын зүйлээр шагнаж урамшууллаа. | 100 |
| | 39 | 3.5.7. “Номын амт “ хүүхдийн утга зохиолын бага наадмыг зохион байгуулна. | 2016-2020 | | | “Бага тайз-2017” урлагийн их наадамд ахлах, бэлтгэл бүлгийн хүүхдийг 5 төрөлд оролцууллаа. Аймгийн Уран жиргээ, Дэгдээхий нас,,Бага тайз, “Үлгэр амьлах цагаар 2017” жүжгийн уралдаан, С.Надмидын нэрэмжит “Номын амт” утга зохиолын бага наадамд оролцож 2-3,4-5 насны ангилалалаар нийт 650 гаруй цэцэрлэгийн насны хүүхдүүд амжилттай оролцлоо.Д.Нацагдоржийн мэндэлсний 110 жилийн ойг тохиолдуулан ханын самбар гаргаж түүний намтар уран бүтээлийг сурталчлах, түүний номоор үзэсгэлэн гаргах, зохиолуудаас сурталчиллаа.Аймгийн төв номын сангаас 12-р ангийн сурагчдын дунд зарласан илтгэлийн уралдаанд нийт 11 сурагч оролцлоо.<br>- “Íîìûí àìò” óëñ, àéìãийí óðàëäààíä òóñ ñóðãóóëèéí сурагчдын àìæèëò:<br>- Á.Ìºíãºí÷èìýã áàãøòàé 4â àíãè õàìò îëîí ìàññààðàà óíøèõ ø¿ëãèéí òºðºëä àéìàãò 1-ð áàéð, öîìûí ýçýí, óëñûí óðàëäààíä 3-ð áàéð òóñ òóñ ýçýëëýý.<br>- Ý.Ìºíõ÷óëóóí áàãøòàé 4à àíãè õàìò îëîí ìàññààðàà óíøñàí íîìîî çóðãààð èëýðõèéëýõ ãàð çóðãèéí òºðºëä àéìàãò 1-ð áàéð, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
